ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗАР
ЗОХИОГЧИЙН ЭРХ БОЛОН ТҮҮНД ХАМААРАХ ЭРХИЙН ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 10 сарын 26 өдөр Дугаар 05 Улаанбаатар хот

Хамаарах эрхийн дуу бичлэг ашиглуулах тарифыг хянан баталгаажуулах тухай

Оюуны өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн 12.2.2 дахь заалт, Зохиогчийн эрхийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн зөвлөлөөс ТОГТООХ нь:

4. Монголын дуу бичлэг бүтээгчдийн үндэсний төв (МСРР) хамтын удирдлагын байгууллагын хамаарах эрхийн дуу бичлэгийг олон нийтэд тоглуулж ашиглуулах, хуулбарлах, дамжуулах, түгээх эрхийг ашиглуулах тарифыг 2026 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн Зөвлөлийн ээлжит хуралдаанаар хянасныг хавсралтаар баталгаажуулсугай.

5. Зөвлөлийн тогтоол танилцуулмагц хүчинтэй болох бөгөөд Зохиогчийн эрхийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.8 дахь хэсэгт заасны дагуу Зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор гомдлоо шүүхэд гаргах эрхтэй.

6. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Зөвлөлийн нарийн бичгийн дарга (Ч.Эрдэнэбаяр)-д үүрэг болгосугай.

ДАРГА Ц.ОЮУНАА
ГИШҮҮД Д.АМАРСАНАА
Ц.ЧИМЭДЛХАМ
Г.БАТ-ОРГИЛ
Г.ЖАНЦАНСАМБУУ
П.БОЛОРМАА
Б.БАТЦЭЦЭГ
М.БАДРАЛ
Г.ТӨВШИНТӨР
С.ДАГВАДОРЖ

1326010008

Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн зөвлөлийн 2026 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 05 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛЫН ДУУ БИЧЛЭГ БҮТЭЭГЧДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ (МСРР) ХАМТЫН УДИРДЛАГЫН БАЙГУУЛЛАГЫН ХАМААРАХ ЭРХИЙН ДУУ БИЧЛЭГИЙГ ОЛОН НИЙТЭД ТОГЛУУЛАХ, ХУУЛБАРЛАХ, ДАМЖУУЛАХ, ТҮГЭЭХ ЭРХИЙГ АШИГЛУУЛАХ ТАРИФ

1. Караоке бааранд фонограм бичлэг тоглуулах үнэ

№	Караоке баарын байршил	Хугацаа	Үнэ (₮)
1	Хотын захын гэр хороололд 1 өрөө	1 сар	20,000
2	Хөдөө орон нутгийн караоке баар 1 өрөө	1 сар	20,000
3	Хотын төвийн караоке баар 1 өрөө	1 сар	30,000

2. Караокед эх бэлдэц үйлдвэрлэх үнэ

№	Эх бэлдэц үйлдвэрлэх нөхцөл (1 бэлдэц, 1 тоглуулагч машин тус бүр)	Үнийн хувь
1	Бэлдэц хийж буй хувь хүн, аж ахуйн нэгж өөрсдөө фонограм хийсэн бол	20%
2	Эх оригинал дуучин, тоглооч, гүйцэтгэгчийн фонограм бичлэгтэй бол	35%
3	Эх оригинал дуучин, тоглооч, гүйцэтгэгчийн фонограм бичлэгтэй, оригинал фото зураг, видео клип бичлэгтэй бол	50%